МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/174 Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч хуулийн этгээд "Хөвсгөл аймгийн бурхан шашинтны төв Мөрөнгийн хүрээ гандан даржайлин хийд" шашны байгууллага (РД:8001472)-ын хүсэлтийг үндэслэн Мөрөн сумын 1 дүгээр багт байршилтай Гандан-2, 204 тоот хаягтай 6712018719 нэгж талбарын дугаартай 47815м^2 сүм, хийд, шашны байгууллагын зориулалттай газраас 1743м^2 газрыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан авто машины зогсоол хийлгүүлэх болсон тул эзэмшил газрын талбайн хэмжээг 46071м^2 болгон багасган өөрчилж, авто машины зогсоол байгуулах газрын 1743м^2 газрыг нийтийн эзэмшилд шилжүүлэн үлдсэн 4 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/547 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

3.Газар эзэмшиж байгаа хуулийн этгээд "Хөвсгөл аймгийн бурхан шашинтны төв Мөрөнгийн хүрээ гандан даржайлин хийд" шашны байгууллагатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-д тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010545